

Юань улсын хаад, хатдын хөрөг зураг дахь дээлийн өнгө, материалын дүрслэлд хийсэн судалгаа

Дашнанжидын Сайхансувд 

Монгол Улсын Боловсролын их сургууль, Дүрслэх урлаг, технологийн сургууль
Улаанбаатар, Монгол Улс
✉ dashnanjidsaihansuud@gmail.com

Хураангуй: Юань улсын хаад хатдын хөрөг зургийн дүрүүдийн дээл хагас дүрслэлтэй тул бидэнд дээлийн энгэр, зах хэсэг; өнгийн талаар мэдээлэл өгөхөөс биш энгэр хэсгээс дооших хэлбэр хийц, хээ чимэглэлтэй байсан эсэх болон дээлийн материалын талаар тодорхой мэдээлэл өгдөггүй. Гэсэн хэдий ч судалгааны бусад эх сурвалжтай харьцуулан үзвэл хөрөг зургууд дээрх дээлийн материалын дүрслэлийг илүү тодруулах боломжтой байна. Тиймээс бид тухайн цаг үед хамаарах археологийн олдворууд болон бичгийн сурвалж, бусад зургийн сурвалжийг нягтлан харьцуулсан судалгаа хийлээ.

Эдгээр хөрөгт дээлийн материал төдийлөн сайн танигдахгүй байгаа ч судалгааны үр дүнгээс ерөнхийлөн үзэхэд тухайн үеийн ихэс дээдсийн дээлийн гол материал нь торго, алтан саатай нагши байсан нь тодорхой байна.

Хөрөг зургууд дээрх дээлийн дүрслэлээс бидэнд шууд тодорхой харагдах зүйл бол өнгө юм. Монголчуудын хувьд ямар үед ямар өнгийн дээл өмсөх нь чухалд тооцогддог байсан тул хөрөг дээрх хүмүүсийн дээл хувцасны өнгийг санамсаргүй байдлаар сонгоогүй нь лавтай. Судалгааны хэрэглэгдэхүүн болох 23 хөрөг дээрх дүрүүдийн 2 нь цагаан, 1 нь ногоон, 1 нь бор шаргал, 19 нь улаан ба улааны төрлийн өнгийн дээлтэй байна. Эдгээр өнгө нь тухайн цагийн монголчуудын дээл хувцасны эрхэм өнгө байжээ. Ялангуяа цагаан, улаан өнгийн хувцас нь ихэс дээдсийн хаан төрийн бэлгэдэл, зэрэг дэвийг илтгэдэг байжээ.

Түлхүүр үгс: хөрөг зураг, дээл, торго, хээ чимэглэл, нагши, өнгө

A Study on the Depiction of Colors and Materials of Deel /Mongolian traditional clothing/ in Portraits of Yuan Dynasty Emperors and Empresses

Saikhansuud Dashnanjid 

School of Fine art and Technology, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia
✉ dashnanjidsaihansuud@gmail.com

Abstract: Because the portraits of Yuan emperors and empresses present their deers only partially, they provide information primarily on color, while offering little detail regarding the form and design, or ornamental patterns below the collar, nor do they reveal clear information about the materials used. However, when these portraits are examined in comparison with other scholarly sources, it becomes possible to more accurately infer the materials represented. Therefore, we conducted a careful comparison of archaeological finds, written sources, and other pictorial sources from that time.

Although the fabrics in the portraits are not always distinctly rendered, the results of existing research indicate that the principal materials used for the garments of the elite during this period were silk and gold-brocaded silk textiles. Color is the one aspect that can be directly and reliably observed from the depictions of deers in the portraits. For the Mongols, the choice of clothing color held significant meaning; therefore, the color of the deers of the people in the portraits was certainly not chosen arbitrarily. Of the 23 portraits examined for this study, 2 are white, 1 is green, 1 is beige, and 19 are red or red-related hues. The results of the research confirm that those colors were the noble colors of the Mongolian deer clothing of the time. Wearing white and red clothes in particular was a symbol of royalty and rank.

Keywords: *portrait, deer, silk, pattern decoration, nasij*

Оршил

Юань улсын хаад, хатдын хөрөг нь дундад эртний монголчуудын хувцсыг судлах үнэтэй сурвалж болдог тул дотоод, гадаадын олон судалгааны ажилд хэрэглэгдэхүүн болгон эш татсан байдаг. Тухайлбал, гадаадын судлаачдаас Эйрен Шеа (2020), Кристин Шиел Лунде (2017), Томас Аллсен (1997) нарын Монголын эзэнт гүрний үеийн дээл хувцасны материал, ялангуяа алтан утастай торгоны талаарх судалгаануудад эш татсан байдаг.

Монголын судлаачдаас Д.Баяр (2004), (2018), У.Эрдэнэбат (2006), (2017), С.Үүрцайх (2025) нарын судалгааг онцолж болно. Д.Баяр Монгол орны дорнод нутгаар зонхилон тархсан XIII-XIV зууны монголчуудын хүн чулуун хөшөөдийн хувцас хэрэглэлийг Юань улсын хаад хатдын хөрөг дээрх дээл хувцасны дүрслэлтэй харьцуулан судалжээ. У.Эрдэнэбат богтаг малгайн талаар бичсэн нэг сэдэвт судалгааны ажил болон, тухайн цаг үед холбогдох археологийн судалгааны ажилууддаа харьцуулан судлах хэрэглэгдэхүүн болгон ашиглажээ. С.Үүрцайх (2025) Юань улсын сударт тэмдэглэгдсэн монгол хувцасны хэв маягийг дүрслэх урлагийн дурсгалуудаар нэхэн тодруулсан судалгаандаа хөрөг тус бүрийн дээл, малгайн хэлбэр хийц, өнгийг тайлбарлан бичжээ.

Гэвч эдгээр хөрөг зураг нь цээж хөргүүд тул дээлийн энгэр хэсэг дүрслэгдсэнээс биш хувцасны ерөнхий хэлбэр хийц бүрэн дүрслэгдээгүй учир бидэнд гүйцэд мэдээлэл өгч чаддаггүй. Түүнчлэн, зурсан арга барил, техник ажиллагаанаас хамаарч дээл хувцасны материаллаг шинж мэдэгддэггүй. Тиймээс бид энэхүү судалгааны ажлаараа хөргүүдийн дээлийн өнгө, материалыг хэрхэн дүрслэн гаргасныг шинжлэн үзэж, Юань улсын хаад хатдын хөргийн дээлний өнгө, хийц, материалыг тодруулах зорилгын хүрээнд бичгийн болон зургийн сурвалж, археологийн олдворуудтай харьцуулан нөхвөрлөн судаллаа.

Судалгааны арга зүй

Юань улсын хаад хатдын хөрөг зураг дахь дээлийн өнгө, материалыг хэрхэн дүрсэлснийг судлахдаа, тухайн үеийн сурвалж бичгүүдэд монголчуудын дээл хувцасны өнгө материалын талаар дүрслэн бичсэн мэдээнүүд болон бусад зургийн сурвалжуудтай харьцууллаа.

Бидний судалгааны хэрэглэгдэхүүн Тайваний үндэсний ордон музейд хадгалагдаж байгаа Юань улсын 8 монгол хаан, 15 хатны, нийт 23 хөрөг зураг бөгөөд өнгө, дүрслэлийг үнэн зөвөөр судлахын тулд бодит эх хөргүүдэд хамгийн ойр өнгө, дүрслэлтэй факсимили хуулбаруудыг баримтлан судалгааг хийв.

Судалгааны үр дүн

Судлаач У.Эрдэнэбат энэ үеийн монголчуудын дээл хувцсыг үндсэн гурван төрөл байна гэж үзсэн бөгөөд Үүнд:

- Урт нарийн ханцуйтай, зөв хандсан ташуу энгэртэй, урт хормойтой дээл
- Дээр өгүүлсэнтэй адил урт нарийн ханцуйтай, тэгэхдээ дээлийн гадуур, тохойноос дээгүүр богино ханцуйтай, хоёр талдаа урт оноотой, дээлтэйгээ тэнцүү урт хормой бүхий өмсгөл
- Ерийн дээлтэй ижил нарийн ханцуй, урт хормойтой, зах заамгүй цулгуй энгэртэй дээл (Дуламсүрэн, Эрдэнэбат, Дэлгэрмаа 2018, 48-49)

Хөргүүдийн дээлийн энгэр зах хэсгүүдээс харахад дээр дурдсан гурван төрлийн дээлнээс ганцхан Өгөдэй хааныг гурав дахь төрлийн дээлтэй дүрсэлсэн бол бусад бүх хаад хатдын хөргийг эхний ангилалд дурдсан дээлтэй дүрсэлжээ. Өгөдэй хааны өмссөн дээл “Хэйда Шилюэ”-д дүрсэлсэн дээлтэй тун төстэй байна. Пэн Дая-ийн дүрслэн бичсэн дээр Сюй Тин нэлээд нарийн ажиглалт хийн нэмэлт бичсэн байдаг. Тэрээр “Дээлний энгэр нь дөрвөлжин гэсэн нь харахад тийм бөлгөө. Мөн зах нь босоо байдаг нь хятад хувцасныхтай адил. Татаарын эзэн, шадар сайд болон эрхэм хүмүүс ийм дээл өмсдөггүй” гэж бичсэн байна (Баясах 2005, 84). Тухайн цагийн хятад хувцасны нэг төрөл нь энгэр зах хэсгээрээ Өгөдэйн дээлтэй төстэй, гэхдээ дугуй энгэртэй байсан. Сюй Тины бичсэнээс үзвэл, мөнхүү дээл нь тэр үеийн монголчуудын энгийн хүмүүс өмсдөг дээл ажээ.

Хөрөг зургууд нь хятадын уран зургийн гонби техникээр торгон дээр бэх, өнгийн будгаар маш олон давхарлан нарийн уусган давхарлаж зурсан учир материаллаг шинжийг тодорхой дүрслэх боломжгүй тул торго, бөс даавуу алин болох нь мэдэгддэггүй. Бичгийн сурвалжууд болон археологийн олдворуудтай харьцуулан үзвэл, ихэс дээдсийн хувцас маш их хээ чимэглэлтэй, материалын хувьд торго голдуу өмсдөг байсан байна. Харин хатдын захны эмжээрийн торгоны хээ чимэглэлийг сайтар нягт нямбай, тоочин дүрсэлсэн байдаг. Тэдний дээлийн захны эмжээр нь нагши торго бололтой. Дээлийн захны эмжээрээс гадна зарим хатдын дотуур өмссөн цамцны эмжээр, богтагны шилэвч, мөн Аюурбарбад, Өлзийт Төмөр хааны малгайн дотор хэсгийн толгойд углах хэсгийг ч мөн нагши торгоор үйлджээ. Нагши торго нь алтан утас гүйлгэн нэхсэн торго бөгөөд Юань улсын хаад ихсийн хувцасны гол материал нь байв. Нагшийг алтан утсаар өнгийн утас, ёнхортой хольж нийтгэн нэхэх буюу дээр нь хатгамалдах, алт түрхэх зэргээр үйлдэх бөгөөд ийм алтан утастай торго нь хамгийн үнэтэй тансаг торгонд тооцогддог

байсан тул ихэс дээдсийн ёслол хүндэтгэл, зүсмийн хувцсанд голдуу ашигладаг байв.

Бидний судалгааны ажлын хөрөг зургууд хадгалалт сайн, өнгө тод учир дээлийн өнгө бидэнд сайн харагдаж байна. Хөрөг зургуудын дийлэнх нь буюу нийт 23 хөргөөс 19 хөрөг нь улаан болон улааны төрлийн өнгөтэй байгааг Юань улсын дунд үеэс хаад, хатдын хөрөг зураг зурах стандарт загвар тогтсон байж магадгүй хэмээн үзэж байна.

Хэлэлцүүлэг

Мөнх хаан /1252 онд/, Хубилай хаан /1275 онд/ тайлга ёслолын хувцасны дүрэм хуулийг удаа дараа гаргасан бөгөөд эдгээр дүрэмд хувцасны материал, ямар дээл хувцсыг ямар торгоор хийх, алтан утастай торгоор чухам ямар хувцсыг хийх, тэдгээрийн хээ угалз, чимэг зүүлт, хэрхэн оёх зэргийг тодорхой тусгаж өгчээ. Үүнээс алтан утаст болон бусад торго, торгоны зүйлээр дээл хувцас үйлдэх тухай заасан дүрмүүдээс дурдвал:

Ёслолын луут дээлийг хар хурмаш сиймхийгээр хийнэ. Дээлний гадарт өнгөт алтан хээтэй байна. Таван өнгийн дотор алт холилдуулж нар, сар, одон гариг, алтан луу гургуул барс ба бичинт хундага зэргийг хатгамлан оёдог. Их бүсийг улаан, цагаан сиймхийгээр нийлүүлж оёж уул бүсэнд хаш гархи хийх бөгөөд алтан хоргой цацгаар чимнэ. Тэрхүү цацгийг алтан хоргой буюу нагшиар хийж дээр нь гурван гархитай, дороо хар ёнхор утсаар зангидсан тортой байна. Хаан зүсмийн хувцсанд голдуу нагши хэмээх алтан хоргой, химарлиг хийнэ. Алтан хоргойгоор дулаан малгай, зун нагши дээл өмсөнө. Түшмэдийн зүсмийн хувцас нь их улаан нагши нэг, улаан химарлиг нэг, ягаан, хөх, ногоон, саарал торгомсог нэжгээд, их улаан торгомсог нэг, хүрэн, шар, хөхөвтөр, хар зэрэг болно. Зуны зүсмийн хувцас 14 зүйл болой. Үүнд, шулуун нагши нэг, утас цугларуулан бүрсэн нагши нэг, ... байна (Нямбуу 2002, 36-39, 54) гэх зэргээр алтан хээ, утаст торгыг хаана хэрхэн хэрэглэхийг нарийн зааж өгчээ.

Юань улсын үед монголчуудын нагши торгон эдлэлийн хэрэглээ үлэмж их нэмэгдсэн. Нагши нь хэр зэрэг үнэтэй торго байсан тухай Рубруккийн тэмдэглэлд “Бидний өмнө насик буюу орны бүтээлэг шиг өргөн маш урт бөс, мөн бухарын торго авчирч тавихыг тушаав. Бид түүний нь авахыг шамдаагүй тул хэлмэрчийг авчруулахад хэлмэрч ирж тэдгээрийг авч билээ. Тэрбээр насик торгоо Кипрт авчраад замд маш их хуучирсан боловч киприйн 80 алтан зоосноос худалдсан билээ” (Рубрук 1988, 172). Рубруккийн тэмдэглэлийн энэ хэсгээс үзвэл, нагши торго нь хуучирсан ч үнэ цэнээ алддаггүй өндөр үнэтэй, тансаг эдлэл байсан нь харагдаж байна. Монгол судлаач Томас Алсен (1997) баруун хойд Иран дахь монголын нийслэл Султаниягийн хамба Уильям Адамд хамаарах “Агуу Каамын эд хөрөнгийн ном” хэмээх 1330 онд бичсэн бүтээлд Юань улсаас асар их хэмжээний торгон хувцас, алтан хувцас олддог, мөн торго, алтан утастай торго асар их байдаг тул маалинган давуу барагтай өмсдөггүй, бүгд торгон цамцтай байдаг тухай өгүүлснийг судалгаандаа дурдсан байдаг. Эндээс үзвэл, хөрөг зургууд дээрх дээл, цамцны эмжээр, богтагны шилэвч, малгайн хэсгүүдэд дүрсэлсэн материал нагши болох нь гарцаагүй байна.

Хөргүүдийн дээлийн материал бидэнд бөс даавуу мэт харагддаг ч тийм биш бололтой. Марко Пологийн тэмдэглэлд Эзэнт гүрний маш олон газар торго нэхэж байсан талаар баримт олонтаа дурдсан нь лавтайяа 30 шахам байна (Сайхансүвд 2020, 69-71). Ер нь түүний тэмдэглэлд очсон газар бүрийнхээ сонин хачны талаар бичихдээ торго, бөс даавуу нэхдэг эсэхийг заавал онцлон бичсэн байдаг. Тэрээр мөн торгоны гааль /татвар/ нэн их тухай бичсэн нь “Энэ газар торго их элбэг. Нэг үгээр хэлэхэд торгоноос 10 хувийн татвар авах бөгөөд энэ нь их мөнгө болно” (Марко Поло 1987, 178). Ялангуяа хятад иргэдэд торгоны алба татвар ноогдуулдаг байснаас хятадын бараг муж бүрд торго нэхэж байв. Юань улсын үед торгон эдлэл улам их дэлгэрч байсны жишээ нь нийслэл хот Ханбалыкт л гэхэд өдөр бүр мянга гаруй тэрэг торго ирдэг байсан талаар дурджээ (Марко Поло 1987, 112).

Өгөдэй хаанд зарим монгол ноёд “Умард хятадын оршин суугчид хэдийгээр эзлэгдсэн боловч ашиг тус даанч алга тул цөмийг нь устгаж нутгийг нь малын бэлчээр болгоё” гэхэд Елюй Чу-цай суурин амьдралтай оршин суугчдаас татвар авч ашиглах буюу жил тутам 500 мянган лан мөнгө, 80 мянган хуй торго, 400 мянган ши үр тариа, их хэмжээний дарс, цуу, давс, төмөр болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг хааны санд авдаг болж болно гэж ойлгуулсан байна (Мункуев 2005, 45). Монголын хаанаас 1221 онд Гуулин улсад илгээсэн тархаах зарлигт халиуны арьс нэгэн түмэн лин, нарин торгомсог гурван мянган толгой, нарин болгосон олс хоёр мянган толгой, мяндас түмэн жин, лунтуан бэх мянган хавтгай, бийр хоёр зуун гуурс, цаас арван түмэн хуудас, бэримуг өвс таван жин, гурум будуг, шунх тус бүр тавин жин, шуруца, шир, тос тус бүр арван жинийг нэхсэн захидал байдаг (Сумьябаатар 1975, 22). “Хар татаарын хэргийн товч”-д тэмдэглэснээр “Хятад газрын ардын уран дархчуулаас бусад эр, эм гэж ялгалгүйгээр жилд хотын ард нэг бүрээс 25 лан ширхэг торго, үхэр хонины гааль 50 лан, ширхэг торгоор татвар авдаг. Хөдөөний тариачны биеэс торго ширхэг нь 100 лан, ... авдаг болно” гэжээ (Баясах 2005, 255).

Торго монголын хаад ноёдын баялгийн санд харьяа орнуудаас татвараас гадна бэлэг, дайны олзны замаар орж ирэх нь их байв. Карпинигийн тэмдэглэлд “Тэнд элчин төлөөлөгчдөөс бэлэглэсэн торго, хилэн, магнаг, хоргой эдлэл, алтан утас ороосон торгон бүс, үнэт чамин үслэг эдлэл, бусад өргөсөн зүйл байх бөгөөд түүнийг нь харахад ч ёстой гайхаад барамгүй. Хааны ордноос нэлээд алсад нэгэн толгой дээр алт, мөнгө, торгон хувцас дүүрэн ачаастай таван зуу гаруй тэрэг хөсөглөн тавьжээ. Тэр бүхнийг эзэн хаан ихэс ноёд хуваан авдаг бөгөөд ноёдууд тус тусад оногдсон хувиас үзэмжээрээ албат харьяат нартаа тараах ажгуу” (Карпини 1988, 72). Хар татаарын хэргийн товчид өгүүлсэнээр “Тэдний улсад энгийн цагт шагнал үзүүлэх явдал үгүй, гагцхүү дайн байлдаанд ялсан үест сая морь хийгээд алт мөнгөн гэрэгэ буюу торго дурдан хоргойг шагналд өгөмүй” гэжээ (Баясах 2005, 261). Юань улсын сударт жил бүр сайд түшмэл гавьяа байгуулсан хүмүүстээ торго, алт, мөнгө, цаасан мөнгөөр бэлэг хүртээсэн тухай маш олон удаа тэмдэглэжээ.

Монголчууд дээл хувцас тэргүүтнээр зогсохгүй торгоор асар майхан, цачир хүртэл томоохон хэмжээтэй эд зүйлс ч гэсэн үйлдэж хэрэглэж байв. Карпинигийн тэмдэглэлд “Биднийг тэнд очиход цагаан магнаг торгон эдээр хийсэн үлэмж том асар хэдийн босгосон бөгөөд тэр нь бидний санахад лавтайяа хоёр мянга гаруй хүн

уужуухан багтахуйц зайтай”, “Бид тэндээс хөдлөөд хятадаас бэлэглэсэн гайхам сайхан гал улаан магнаг цачир барьсан өөр нэгэн газар хүрч ирлээ” (Карпини 1988, 69,73), Марко Пологийн тэмдэглэлд “Орд өргөө, асар танхимыг оосор бүчийг үнэт торгомсог зүйлээр үйлджээ. Өчүүхэн бага хүн болбоос гурван цацрын үнийг төлж эс чадна” (Марко Поло 1987, 110) гэх зэргээр тэмдэглэжээ.

Торгоны тухай цөөн баримт дурдахад ийм байхад торго бол Юань улсын ихэс дээдсийн дээл, хувцасны үндсэн гол материал торго байсан нь тодорхой байна. Ялангуяа тухайн цагийн дэлхийн торгоны гол үйлдвэрлэгчдийг харьяандаа нэгтгэн торгоны зах зээлд монополь байсан Юань улсын хаад хатдын дээл энгийн цулгуй бөс даавуу байгаагүй нь лавтай.

Бүх хөрөгт дээлийг цулгуй дүрсэлсэн ч хатдын дээлийн эмжээрийн хээг нягт нямбай тоочин дүрсэлжээ. Хатдын дээл бүгд нэг өргөн, хоёр нарийн эмжээртэй байх бөгөөд өргөн эмжээр нь хоёр янзын хээтэй ажээ. Нэг нь Юань улсын үеийн бэлгэдэлт цэцэг болох 6 дэлбээтэй дэлдүү цэцгэн хээтэй. Үүнийг 9 хатны хөрөгт дүрсэлжээ. Нөгөөх нь чандмань маягийн хэлбэр дотор үүлэн хээг зохиомжлон хийсэн хээтэй бөгөөд үүнийг 6 хатны хөрөгт дүрсэлжээ. Дунд болон гадна талын нарийн хоёр эмжээр нь алтан дэвсгэр дээр улаан, хар нарийн шугамаар шувуу, цэцэг, ургамал дүрсэлжээ.

Археологийн олдвороор илрэн гарсан Юань улсын үед хамаарах дээлнүүд болон энэ үеийн торгон эдлэлийн судалгаануудаас үзвэл, дээл хувцасны бөс даавуу, торго нь ихэнхдээ маш баялаг хээтэй байдаг. Тухайлбал, С.Дуламсүрэнгийн цуглуулгад байх Юань улсын үед хамаарах магнаг торгон ёслолын эмэгтэй дээл маш баялаг хээ чимэглэл, гоёмсог ур хийцтэй байна. Дээлийн үндсэн дэвсгэр өнгөлсөн материал нь торгон дээр навч цэцэг ба галуу шувуудыг өнгө алаглуулан дүрсэлсэн хээтэй. Торгоны дэвсгэр өнгө шар бөгөөд цэцгийн дэлбээ, иш найлзуур, навч нахиа, шувууны бие хошуу, нүд хөлийг улаан, ногоон, шар, хөх, хүрэн өнгөөр солбиулан уран тансаг зохиомжийг бүрдүүлжээ. Уг дээлийн ханцуйн бугуй, суганы хэсэг, энгэр хормойг дагуулан алтан утастай торгоор гол болгож тус бүр 2 см өргөн зурвас гаргаад захыг нь шар хүрэн, ногоон утсаар гурав гурван эгнээ зээг тавьж бугуйн үзүүрт захын хоёр, түүний дотор талын хэсэгт дунд талын дэвсгэр болгож бор өнгийн даавуу хавчуулан цаваг тавьж оёжээ. Дээлийн дал мөр ба энгэрийг мөрөвч хэлбэрээр угалз гарган оёж чимэглэсэн байна. Энэхүү дээл нь Юань улсын үеийн эмэгтэй дээл хичнээн гоёмсог хээ чимэглэл ур хийцтэй байсныг бүрэн илтгэх жишээ болно (Дуламсүрэн 2018, 133-134).

Дээл хувцасны хээг хамгийн тодорхой дүрсэлсэн энэ үеийн зураг нь Лю Гуаньдаогийн “Хубилай хааны ан” хэмээх зураг юм. Хубилай хаан энгэр хормой дээрээ алтан утсаар луу нэхсэн улаан торгон дээлтэй байгаа бол Чаби хатан мөн л гоёмсог эмжээртэй алтан утсаар хээ гарган нэхсэн цагаан торгон дээл өмсжээ. Түүний унасан морины эмээлийн гөлөм, олонцог ч мөн алтан утаст хээтэй ажээ. Бас сум тавих гэж буй ногоон дээлт, морин дээрээ ардаа ирвэс суулгасан бараан дээлт, гар дээрээ цагаан шонхор суулгасан цэнхэр дээлт, улаан дээлтэй өнгөт арьст хүмүүсийн дээлний энгэр, мөр, ар хэсэг алтан утаст хээтэй байна. Лю Гуаньдао Жи-Юанийн 16 дугаар он /1279 он/-д хаад хатдын хөрөг зураг зурахдаа гойд гарамгайнхаа ачаар дээдсийн хувцас өмсгөлийг урлах албанд томилогдож байв

(Фөн Минжу 2015, 61). Дээл хувцас урлах албаны ажилтай байсан тэрээр энэ зурагтаа дээл хувцасны загвар дизайн, хээ чимэглэл зэргийг үнэн зөв, тодорхой дүрсэлсэн байж таарна.

Судлаачид эдгээр хөргийг тахил тайлгын хөрөг зургуудын загвар зураг гэж үздэг. Бидний судалгааны ажлын хатдын хөрөг Ямандагийн мандал торгон нэхмэл дээрх хоёр хатны дүрслэлтэй, Тугтөмөр хааны хөрөг, мөн Ямандагийн мандал болон төвөдийн Потала ордонд хадгалагдаж байгаа түүний шүтээн зурагтай зохиомж, нүүр царайны байдал, дээлийн өнгө зэрэг нь маш адилхан атлаа бидний судалгааны ажлын хэрэглэгдэхүүн болох хөрөг зургуудаас ялгаатай нь дээлийн хээг маш тодорхой тоочин дүрсэлсэн байдаг (Зураг 1, 2, 3, 4, 5, 6).

Юань Чэний үзэж байгаагаар “Юанийн хаадын хөргийг бүтээх хамгийн тохиромжтой арга нь цаасан дээрх зураг биш, харин торгон нэхмэл хийх явдал байв. Өөрөөр хэлбэл, Тайваний үндэсний ордон музейн цуглуулгад байгаа Юань улсын хаадын зургууд нь хаадын бие галбирын онцлогийг хадгалах зорилгоор хийсэн загвар юм. Тиймээс бид энэ цомогт дүрслэгдсэн эзэн хааны хувцасны өнгийг Юань улсын ихэс дээдсийн хувцасны жинхэнэ бодит дүрслэл гэж үзэх ёсгүй” (Yuan Julian Chen 2014, 352) гэжээ. Эндээс үзвэл, эдгээр хөрөг нь загвар зураг тул тухайн хүнийхээ бодгал шинжийг чухалчилснаас хувцасны материал, хээ чимэглэлд ач холбогдол өгөөгүй бололтой.

Гэхдээ өнгийн хувьд Юань Чэнийн үзэлтэй санал нийлэхгүй байна. Учир нь Монгол угсааны төрт улсуудад эртнээс нааш ямар үед ямар өнгийн дээл өмсөх нь чухал байсан. Тухайлбал, Хүннүгийн гаралтай аймаг угсаатанд цагаан дээл эрхэмлэх ёс байсан. Сяньбичууд улаан өнгийн дээл хувцсыг эрхэмлэдэг байв (Сүхбаатар 2001, 135). Хятан нарын тайлгын хувцсанд: “Их тайлганаа хаан нь цагаан нягт хив дээл, улаан бүс, бага тайлганаа хаан нь хатуу малгай, улаан утсаар оёсон дээл, хатан нь улаан хив алчуур нөмөрнө. Төрийн хувцсанд хаан улаан дээл, түшмэл сайд нар хүрэн дээл өмсөнө. Албаны хувцсанд хүрэн чухал дээл, хаст бүс болон улаан дээл орно. Түшмэл хүн хүрэн дээл өмсөнө” гэсэн байдаг (Нямбуу 2002, 22).

Марко Пологийн тэмдэглэлд “Тэдний он нь хоёрдугаар сард эхэлдэг. Их хаан, түүний бүх харьяат нь баяр хийхдээ эрэгтэй, эмэгтэйчүүд цөм чадлынхаа хэрээр цагаан хувцас өмсдөг заншилтай. Тэд цагаан хувцсыг бэлгэ дэмбэрэлтэй гэж үздэг. Тэгээд бүхэл жилдээ аз хийморьтой байхын тулд цагаан хувцас өмсдөг” гэж бичжээ (Марко Поло 1987, 103).

Гүюгийг хаан ширээнд залах Их хуралдайн тухай Плано Карпинигийн тэмдэглэлд “Биднийг тэнд очиход цагаан магнаг торгон эдээр хийсэн үлэмж том асар хэдийн босгосон бөгөөд тэр нь бидний санахад лавтайяа хоёр мянга гаруй хүн уужуухан багтахуйц зайтай ...”, “Эхний өдөр цөм цагаан магнаг торго, дараагийн өдөр нь улаан магнаг торгон хувцас өмссөн бөгөөд тэгэхэд нь мөнөөх асарт Гүюг морион ирсэн билээ” (Карпини 1988, 69) гэсэн байдаг.

Юань улсын тайлга ёслолын хувцасны дүрэмд, Хааны зүсмийн хувцсанд улаан, ягаан, хүрэн, хөх, ногоон, цагаан хувцас, түшмэдийн хувцсанд их улаан нагши, ягаан, хөх, ногоон, саарал, хүрэн шар, хөхөвтөр зэрэг өнгийг заасан байдаг бол, Хэйда Шилуэ-д тухайн цагийн монгол хүмүүсийн дээлийн өнгийг улаан, нил ягаан, ногоон гэж бичжээ (Баясах 2005).

Дээрх мэдээнүүдээс үзвэл, албан ёсны хэв маягтай эдгээр хөрөг зурагт дээлийн өнгийг санаан зоргоор дүрслээгүй нь лавтай байна. Дээр дурдсан сурвалжийн мэдээнүүдээс үзвэл, монголчуудын дээлийн хамгийн эрхэм өнгө цагаан, улаан болох нь тодорхой харагдаж байна. Хөрөг зургуудад Чингис болон Хубилай хааныг цагаан дээлтэй, Өгөдэй хаан, Нахан хатан нарыг бор шаргал дээлтэй, Ренчинбал хааныг ногоон дээлтэй, бусад дүр буюу 15 хатан, 4 хааныг улаан, улаан хүрэн, улаан ягаан дээлтэй дүрсэлжээ.

Цуглуулагч С.Дуламсүрэнгийн цуглуулганд байгаа Юань улсын үеийн ёслолын эмэгтэй дээл /улаан өнгийн дотортой, шар дэвсгэр дээр гоёмсог хээ чимэглэлтэй, магнаг торгон дээл/, Нартын хадны оршуулгаас гарсан даавуун тэрлэг, ёслолын дээл /улаан дэвсгэр дээр алтан утсаар нэхсэн луун хээ болон далавчаа дэлгэн нисч буй толгойдоо өрвөлөгтэй жижигхэн махир хошуутай, богино сүүлтэй тоть мэт шувууны дүрстэй торгоор залгаж зүйж оёсон эмэгтэй дээл/, Гозгор толгойн оршуулгаас гарсан эмэгтэй дээл, давхац дээлний тасархай /цэцгэн хээтэй улаан шаргал торгон дээл, алтан утсаар нэхсэн битүү үүлэн хээтэй улаан шар өнгийн торгон давхац дээл/, Зүүн Байдлагийн хадны оршуулгаас гарсан дээл /улаан хүрэн өнгийн ёрог даавуун гадаргай хурган дотортой эрэгтэй дээл/, Ёдортын хадны оршуулгаас гарсан дээл /бор шаргал өнгийн торгон эмэгтэй дээл/ гэх мэт археологийн олдвороор гарсан дээл хувцас, зургийн бусад сурвалж, бичгийн сурвалжуудаас ч тэр үзвэл тухайн үеийн монголчуудын дээлний зонхилох өнгө нь улаан байсан нь харагддаг. Үүнийг туульсын баатруудын дүрээс ч тодорхой харж болно. Туульсийн баатруудыг цог хийморь амин сүлдийн өөдлөх уруудахыг бэлгэдэж улаан хувцастай дүрсэлсэн нь олонтаа. Энэ талаар С.Дулам “Заавал улаан өнгийн цамц байдаг нь хүний биед хэрцэлдэн булиглагч шунхны /цусны/ өнгөтэй төрөлсөж буй хийгээд амин улаан шим бүрдмэл байхын бэлгэдэл бололтой. Энэ өгүүлэмж бол угтаа бөө мөргөлийн язгуур үзэлд буй аливаа эд зүйлийг амилуулж амьтай эзэнтэй болгож, түүний өнгө байдлаар шинжиж болдог төсөөллийн улбаа юм” (Дулам 2011, 47-48) гэж тайлбарлажээ.

Харин цагаан өнгийн дээл хувцас нь монгол хаадын төрийн ёслол хүндэтгэлийн бэлгэдэлтэй холбоотой юм. С.Дулам “зан үйл, тайлга тахилга, бөө мөргөлийн ёс заншилд цагаан өнгийн бэлгэдлийн утга аяс нь илүү тодорхой ялгарч ирдэг. Цагаан өнгө нь Монголчууд тэнгэрт сүү цацаж өргөл өргөх ёс заншлаар дамжуулан тэнгэрт шүтэх ёстой шууд холбоотой. Иймээс цагаан өнгө нь нарны туяа, өдөр (гэрэл) болон баруун тэнгэрийг төлөөлдөг онгод сахиулах монголчуудын уламжлалт бэлгэдлийн гол цөм юм” (Дулам 2011, 16) гэж үзжээ. Судлаач Ц.Уранчимэг төрт ёсны үйл дэх цагаан өнгөний бэлгэдлийн талаарх судалгаандаа

Өвөг дээдсийн сүлд тахих ёслолд цагаан жишгийг баримталдаг байсан. “Найман цагаан гэр”-ийн материаллаг соёлд ч энэ өнгөний тухай бэлгэдэл бий. Карпини янз бүрийн өнгөтэй эзэнт гүрний хуарнуудын тухай бичсэн. Тухайлбал, алтан ордонд эзэн хааны хаан ширээнд залрах газар, “Шар Орду” (Шар ордон) нь шүүх, цагаан ордонд хаан ширээнд залрах ёслол болохоос гадна хаан болон түүний эхнэрүүд амьдардаг байв. Эндээс үзвэл цагаан өнгө нь эзэн хааны орд, түүний агуу их хурал, хүч чадлын бэлгэдэл юм. Иймээс цагаан өнгө нь Хорихосунд Чингис хааны хөрөг дээрх хувцсыг сонгоход чухал өнгө байсан (Uranchimeg 2021, 46-47) гэж үзжээ.

Ямандагийн мандал торгон нэхмэлд Тугтөмөр хааныг гадна талаараа цагаан дээлтэй дүрсэлсэн байна. Тугтөмөр хаан 1328 оны 10-р сарын 16-аас 1329 оны 04-р сарын 03-ны хооронд хаан сууж байгаад эцэг Хайсан хаан амьд ахуйдаа ахмад хүү Хүслэнг хаан суухыг нэр зааж байсан тул ахдаа хаан ширээг шилжүүлж, Хүслэн хаан Тугтөмөр хааны хоёр удаагийн хаанчлалын хооронд буюу 1329 оны 1 сарын 26-аас 1329 оны 8 сарын 6-ны хооронд зургаан сарын турш засгийн эрх барьсан. 1329 оны 8 сарын 3-ны өдөр Хүслэн хаан Тугтөмөртэй уулзан найр хийсэн ба найрын үеэр Хүслэн хаан гэнэт учир битүүлгээр насан эцэслэжээ. Хожим түүний ахмад хүү Тогоонтөмөр хаан эцэг эхийн өш санаж Өвгөдийн сүм дэх харшийг нь устгаж, онгоныг нь нурааж байжээ.

Ямандагийн мандал торгон нэхмэлийг Тугтөмөр хаан дахин хаан суумагцаа 1330-1332 оны хооронд хийлгэсэн ба ахыгаа хөнөөсөн гэх хэргийг нуун далдлахын тулд ах дүүсийн эв найрамдлын хуурамч дүр үзүүлэхийг оролдож зэрэгцэн суугаагаар дүрсэлсэн төдийгүй Тугтөмөр өөрийн болон дүүгийнхээ хувцсанд зориудаар өөр өнгийг ашиглаж өөрийгөө цагаан хувцастай дүрсэлсэн нь эзэн хааны хувьд хууль ёсны гэдгээ онцолсон бололтой (Yuan Julian Chen 2014, 353).

Цомгийн хөргүүдээс Чингис хаан, Хубилай хаан хоёрыг л цагаан дээлтэй дүрсэлсэн нь Чингис хаан бол Их Монгол улсыг үүсгэн байгуулагч, Хубилай хаан бол Юань улсыг үндэслэгч гэсэн санааг илтгэсэн бололтой.

Судлаач Юань Чэн (2014) Юань улсын хаад хатдын хөрөг хадгалагдаж байсан Нан Сюн Дян харшийн хадгаламжид байгаа Сүн улсын арван зургаан хааны хөргийг судалж үзээд нэгэн сонирхолтой таамаглал дэвшүүлжээ. Тэрээр Сүн улсын хаадын хөргүүдийг хоёр бүлэгт хувааж үзээд, 1-р бүлэгт, Сүн улсын эртний 6 хаан, 2-р бүлэгт, дараачийн 10 эзэн хааны дүрийг багтаан тэдний зохиомжийн шийдэл, зурсан арга барил, ялангуяа дээл хувцасны өнгөнд дүн шинжлэл хийжээ. Нэгдүгээр хэсгийн 6 хааны хөрөг суугаа, босоо, баруун, зүүн тийш харсан гэх мэт янз бүрийн зохиомжтой, зарим хааны хувцасны хээг нарийн тоочин дүрсэлсэн, 3 хаан нь цагаан хувцастай байхад үлдсэн 3 хаан нь улаан өнгийн хувцастай гэх мэт тогтсон хэв маяггүй байхад, 2-р бүлгийн 10 хааны хөрөг бүгд улаан хувцастай, ижил зохиомжтой жигд хэв маягтай дүрсэлсэн байна. Эндээс үзвэл, анхны зургаан эзэн хааны зургийг стандартчилахаас өмнөх туршилтын үе шатанд бүтээж хожмын хаадын хөрөг зургийг хаадын хөргийг бүтээх тогтсон хэм хэмжээний дагуу бүтээсэн гэж үзжээ.

Юань улсын судрын 75-р дэвтэр, Тайлга, тахилгын тэмдэглэлд “Хубилай хаан “Чжи Юань-ын 15-р оны (1278) 11-р сард зарлиг буулгаж Тайзу-ын (Чингис) гэгээн дүрийг зурахыг Хорихусунд тушаав. Хубилай хаан 1279 оны 2-р сард Хорихусунд дахин зарлиг буулгаж Есүхэй баатар, Тулуй, Өгөдэй нарын хөргийг зурахыг даалгажээ” (дам эшлэв Содбилэг 2010, 406-407) гэжээ. Юань улсын тэмдэглэл болон Юань Чэний судалгаан дээр үндэслэн бодвол Юань улсын эхэн үед Хубилайгаас өмнөх хаадын хөргийг монгол зураач зуржээ. Ингэхдээ ямар нэгэн жишиг баримтлаагүй зурсан. Хубилайгаас хойших хаадын хөргийг төвөд, хятад зураач нар зурсан байх магадлал өндөр. Тэд Сүнгийн үед баримталж байсан эзэн хаадын хөргийг бүтээх жишиг загварыг тодорхой хэмжээнд баримтлан хятад болон монголчуудын дээл хувцасны эрхэм өнгө улаанаар бүтээх жишиг тогтсон байж болох юм.

Дүгнэлт

Эдгээр хөрөг зургийн технологи арга ажиллагааны онцлогоос хамаарч хувцасны материалыг тодорхой үзүүлэх боломжгүй тул бөс даавуу, торго алин болох нь мэдэгдэхгүй ч судалгааны үр дүнгээс харахад Юань улсын хаад, хатдын дээлийн гол материал торго болон алтан саатай нагши байсан нь гарцаагүй байна.

Юань улсын ихэс дээдэс маш баялаг хээ чимэглэлтэй хувцас өмсдөг байсан боловч хөрөг зургуудад хаадын дээл хувцасны хээ чимэглэлийг тоочин дүрслээгүй нь эдгээр хөрөг нь тахилын хөрөг зургийн загвар зураг учраас тэр бололтой. Тийм учраас эдгээр хөрөг дээрх дээлийн дүрслэлээр монгол хаад, хатдын дээлийг шууд төлөөлүүлэн ойлгож болохгүй гэдгийг харуулж байна.

Харин хаад, хатдын дээлийн өнгө нь сурвалж бичгүүдийн мэдээнд бичсэн монголчуудын дээл хувцасны эрхэм өнгөнүүдтэй тохирч байгаа бөгөөд дээлийн өнгө нь ихэс дээдсийн төрийн бэлгэдэл, зэрэг дэвийг илтгэдэг байжээ.

Мөн Сүн улсын хаадын хөрөг зурагтай харьцуулан үзсэний үндсэн дээр Юань улсын хаад хатдын хөрөг Хубилай хаанаас хойш ихэс дээдсийн хөрөгт дээл хувцасны өнгийг бүтээх жишиг загварт орсон бололтой гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

- Баясах, Жамсран. 2005. *Их монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг*. Улаанбаатар.
- Гильом де Рубрук. 1988. *Дорно этгээдэд зорчсон минь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Дулам, Сэндэнжав. 2011. *Монгол бэлгэдэл зүй. Дэд дэвтэр*. Улаанбаатар: Битпресс.
- Дуламсүрэн, Сүхээ. 2018. *Нүүдэлчдийн торгон урлал*. Улаанбаатар.
- Жиованни дель Плано Карпини. 1988. *Монголчуудын түүх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Марко Поло. 1987. *Орчлонгийн элдэв сонин*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Мункуев, Н.Ц. 2005. *Монголын анхны хаадын тухай хятад эх сурвалж*. Улаанбаатар.
- Нямбуу, Ханд. 2002. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар.
- Фөн Минжу. 2015. *Тайваний үндэсний “Хааны ордон” музей дэх Монголын түүх, соёлын өв дурсгалууд*. Тайвань.
- Сайхансүвд, Дашнанжид. 2020. “XIII-XIV зууны монголчуудын торгон эдлэлийн хэрэглээ.” *Монголын дүрслэх урлаг, дизайны хөгжил*: 60-73.
- Содбилэг, Чулуунбаатар. 2010. *Монголын их Юань улсын түүх*. Улаанбаатар: Бэмби сан.
- Сумъяабаатар, Б. 1975. *Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудал*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэлийн газар.

Сүхбаатар, Гүнж. 2001. *Монголын эртний түүх судлал. II боть. Сяньби.* Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Thomas T. Allsen. 1997. *Commodity and exchange in the Mongol empire.* Cambridge University Press.

Uranchimeg Tsultem. 2021. "The portrait of Chinggis Khaan: Revisiting the Ancestral Connections." *Water moon reflections. Essays in honor of Patricia Berger:* 34-57.

Yuan Julian Chen. 2014. "Legitimation Discourse and the Theory of the Five Elements in Imperial China." *Journal of Song-Yuan Studies.* 44(1): 325-364.

Хавсралт



Зураг 1. Чаби хатан. Торго, будаг, бэх, 48x61,5. Тайванийн үндэсний ордон музей



Зураг 2. Ямандагийн мандал. Торгон нэхмэл. 245.5 x 209 см. Метрополитан музей.



Зураг 3. Хүслэн хааны хатан. Торго, будаг, бэх, 48x61,5. Тайванийн үндэсний ордон музей



Зураг 4. Тугтөмөр хаан. Торго, будаг, бэх, 48x61,5. Тайванийн үндэсний ордон музей



Зураг 5. Тугтөмөр хаан. Потала ордон



Зураг 6. Тугтөмөр хаан. Ямандагийн мандал. Торгон нэхмэл. 245.5 x 209 см. Метрополитан музей